



“Хөвсгөл Алтандуулга” ХХК-ийн 2025 оны эхний хагас жилийн тайлан

2025 он

Агуулга



Хүний нөөц, бичиг хэрэг



Аж ахуй



Боловсруулах үйлдвэр




**KHUVSGUL
ALTANDUULGA**

Хүний нөөц, бичиг хэрэг

2025 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар “Хөвсгөл Алтандуулга” ХК нь нийт 6 нэгжийн 48 ажилтантайгаар хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна. Ажилтнуудын бүтэц, хуваарилалт нь байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааг жигд, тасралтгүй хангах чиглэлд зохион байгуулагдсан бөгөөд хүний нөөцийн тогтвортой байдлыг хадгалах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.

Орон
Тоо

Хүйс



26

22

Архив, бичиг хэрэг



2023 оны бүх баримт бичгийг архивын журмын дагуу ангилан дугаарлаж, цахим хувилбарыг бэлтгэн сканнердаж, нэгдсэн бүртгэлд оруулсан.

Архивын бүртгэл шинэчлэгдэж, 2025 оны ажилд ашиглах нөхцөл бүрдсэн.

Хүний нөөцийн мэдээлэл шинэчлэх ажил



2024 оны ажилтнуудын хувийн мэдээллийн санг шинэчлэх ажлыг эхлүүлж, ажилтны судалгаа, бүрдүүлэлтийн үйл явц явагдаж байна.

Шинэчлэлтийн хүрээнд төрийн албан ёсны мэдээлэлтэй уялдуулах, цахим санг сайжруулах зорилт тавьсан.

Соёл, спортын үйл ажиллагаа



“Хөвсгөл Алтандуулга” ХК болон “Алтан Хажир” ХХК-ийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг нээлттэй хэлбэрээр амжилттай зохион байгуулав.

Уг тэмцээнд нийт 23 багийн 180 гаруй тамирчин оролцож, хамт олны уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэв.

Сургалт, мэдээллийн үйл ажиллагаа



“Хөвсгөл Алтандуулга” ХК, “Алтан Хажир” ХХК болон “Монгол Фармерс Маркет” ХХК-ийн ажилчдад зориулсан 8 цагийн ХАБЭА-н сургалт зохион байгуулж, оролцогчдоос анхан шатны мэдлэгийн шалгалт авч, бүртгэлжүүлсэн.

Сургалтад нийт 42 ажилтан хамрагдаж, мэдлэгийн шалгалтыг амжилттай хамгаалсан.

Компанийн дотоод журам болон Хөдөлмөрийн тухай хуулийн хэсгээс нийт ажилчдад мэдээлэл, сургалт зохион байгуулсан. Нийт 30 ажилтан хамрагдсан.

Урт хугацааны баярын амралт болон цаашдын үйл ажиллагааны чиглэл, дотоод асуудлын талаар хэлэлцэх нийт ажилчдын хурал зарлан, зарим асуудлуудын талаар оновчтой шийдэлд хүрсэн.

Нийгмийн хариуцлага, хүүхдийн баярын арга хэмжээ



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан компанийн 38 ажилтны 71 хүүхдэд зориулан 4 насны ангиллаар гарын бэлэг бэлтгэн хүргүүлэв.

Энэхүү үйл ажиллагаа нь ажилчдын сэтгэл ханамж, байгууллагын нийгмийн хариуцлагыг дэмжсэн чухал үйл явдал болов.

Мөн тус өдрийг тохиолдуулан сумын зорилтот бүлгийн 1 хүүхдэд гарын бэлэг бэлтгэн, хүндэтгэл үзүүлэв.

Тусламж, тэтгэмж



Ажилтнуудын сургалт, хувийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, ар гэрийн гачигдал, хүндрэлийн үед туслалцаа үзүүлэх зэрэг бодлогыг компанийн дотоод журамд нийцүүлэн шуурхай, уян хатан идэвхтэй хэрэгжүүлэн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах чиглэлд анхаарч ажиллаж байна.

ДҮГНЭЛТ



2025 оны эхний хагас жилд Хүний нөөц, бичиг хэргийн алба нь баримт бичгийн хөтлөлт, хүний нөөцийн мэдээллийн сангийн шинэчлэл, ажилтны сургалт, хамт олны уялдаа холбоо болон нийгмийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, байгууллагын дотоод үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулахыг зорин ажиллалаа.

Цаашид эхний хагас жилд хийсэн ажлын үр дүнг бататган, хүний нөөцийн чадавх, цахимжуулалт, ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Хавсралт зураг. Спортын арга хэмжээ




Хавсралт зураг. Хүүхдийн гарын бэлэг



Хавсралт зураг. Сургалтууд







Аж ахуй

Хаврын улиралд мод, бут сөөгийн цэнэг усалгаа хийж мөн байгууллагын хашаа, орчны талбайд шинээр мод тарьж, ногоон орчин бүрдүүлэхэд анхааран ажиллалав.

Байгууллагын хашаа болон орчны тохижилт, ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор хүнсний ногоо тарьж, газрын бэлтгэл, үрсэлгээ, усалгаа, арчилгааны ажлыг хийв.

Байгууллагын хашаа, агуулах, гадна орчны бүсэд хортон шавьж, мэрэгчдийн эсрэг ариутгал, шавьж устгалын ажлыг хийж, халдвар хамгааллын нөхцөлийг сайжруулав.

Байгууллагын хашааны шар өвс, хогийг цэвэрлэж, газрын шороог зөөлрүүлэн тэгшилж, орчны өнгө үзэмжийг сайжруулах тохижилтын ажлыг хийж гүйцэтгэв.

Байгууллагын удирдлагын байрны дотор болон гадна талыг угааж цэвэрлэх, цонх, хаалга, хана, шал зэрэг бүх хэсэгт ерөнхий цэвэрлэгээ хийж, ажлын орчны эмх цэгц, цэвэр байдлыг ханган ажиллав.





Байгууллагын хашаа болон орчны газарт ургасан зэрлэг ургамлыг түүж цэвэрлэх, ургалтыг багасгах зорилгоор зэрлэг ургамлын устгалын ажлыг тогтмол зохион байгуулан гүйцэтгэлээ.




Байгууллагын гадна орчны өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор олон төрлийн цэцэг тарьж, тогтмол усалгаа, арчилгааг хийж гүйцэтгэлээ. Энэхүү ажил нь байгууллагын орчныг илүү тохилог, үзэмжтэй болгоход эерэг нөлөө үзүүлсэн.



Байгууллагын нэр дээр бүртгэлтэй баарны хашааны эвдэрч муудсан хэсгийг нөхөн сэргээж, шон, хашааны хэсгийг засварлан, тохижилт, аюулгүй байдлыг хангах чиглэлээр засварын ажлыг хийж гүйцэтгэлэв.



Байгууллагын хашаанд байнга ашиглагддаг био 00-ын бохир ус, хаягдлыг зориулалтын автомашинаар соруулж, цэвэрлэгээ хийв. Ингэснээр орчны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, үнэр, бохирдлын эх үүсвэрийг арилган, ажилтнууд болон зочдын тав тухтай байдлыг хангах нөхцөл бүрдүүлэв.



Хавсралт зураг








ДҮГНЭЛТ

2025 оны эхний хагас жилийн хугацаанд аж ахуйн нэгж нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжих, орчны тохижилт, цэвэрлэгээ, ариутгал, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээ, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах чиглэлээр төлөвлөгөөний дагуу ажлуудыг гүйцэтгэн ажиллалаа. Тус хугацаанд нийт 9 төрлийн ажил тогтмол, уялдаа холбоотой зохион байгуулагдаж, байгууллагын орчны цэвэр, тохилог байдал, ажилтнуудын ажлын нөхцөлд эерэг нөлөө үзүүлсэн.

Цаашид улирлын онцлогт тохируулан ногоон байгууламжийг өргөтгөх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, ажлын байрыг эрүүл, аюулгүй, цэгцтэй байлгах зорилтуудыг шат дараатай хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Боловсруулах үйлдвэр



- ✓ Дээд гурилын босоо агуулахыг 5 тонн багтаамжтай байсныг 10 тонн болгож нэмж өндөрлөв.
- ✓ Савлагааны хэсгийн хаалга шинээр хийж угсрав.
- ✓ Агуулахын хаалга мөн адилаар хийж гүйцэтгэв.
- ✓ Гурилын нори болгон тоосжилт ихтэй байсан тул эсгийгээр жийргэвч хийв.

★ Хуучин үйлдвэрийн дээвэр солих ажлын эх бэлтгэл хуучин дээврийн дулаалга хэсгийг хуулж зөөвөрлөв.

★ Нэмж цутгалт авахаар дээврийн хөрс тэгшилгээ хийж бэлтгэн цементэн хучилт хийж гүйцэтгэв.

★ Төмөр дээвэртэй хэсгийн дээврийн төмрийг бүрэн солихоор төмөр захиалга хийгдээд татан авалт 100% хийгдсэн дээвэрлэлт 40% байна.





50ш поддон түүхий эдийн худалдан авч 5см банзаар хийж гүйцэтгэв. Мөн нэмж 50ш хийхээр төлөвлөж байгаа бөгөөд түүхий эд болох мод захиалга хийсэн байна



50ш поддон түүхий эдийн худалдан авч 5см банзаар хийж гүйцэтгэв. Мөн нэмж 50ш хийхээр төлөвлөж байгаа бөгөөд түүхий эд болох мод захиалга хийсэн байна



Үйлдвэрт дагалдаж ирсэн болон суурилуулалтаас илүү гарсан сэлбэг бараа материалыг бүгдийг гаргаж контейнерт нь тавиур угсарч эмхэлж цэгцлэв.

- Байгууллагын ерөнхий план болох кадастрыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж зургийг архивд шилжүүлэх ажлыг хийв.
- Хуучин агуулахад 240 тонн орчим хивэг хурааж үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний агуулахад гурил хэвтэлт хангах анхан шатны ажлыг эхлүүлэв.хураасан хивгийг ус борооноос хамгаалж 3-н давхар хучлагаар хучив.
- Үйлдвэрээр хаврын тариалалтын үрийн буудайг бүрэн цэвэрлэж стандартад нийцүүлэн бэлтгэв.
- Боловсруулах үйлдвэр нь 1 ээлжээр хагас жилийн хугацаанд 1,816,000 тонн улаанбуудайг тээрэмдэж олон нэр төрлийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж,хэрэглэгчдийн хэрэгцээ захиалгын дагуу савлаж бэлтгэн нийлүүлэв.

Сар	Дээд гурил	%	1-ргурил	%	Хивэг	%	3-р гурил	%	2-р гурил	%	Бүхэл үр		Нийт дүн
1	12,525		144125		60,000		10,475				1,350		228,475
2	77577		165495		70,325		11,550		17,775		1,300		344,022
3													
4	68,200		83,525		58,475		6,400		15,150		23136		254,886
5	53,150		164850		37275				9,900		20,300		285,475
6	97,650		386900		148,525		11,625		24,625		34355		703,680
Нийт дүн													1,816,538



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА